

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 03 сарын 10-ны өдөр

Дорноговь аймаг

№	Гүйцэтгэх ажил, арга хэмжээний чиглэл	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хэрэгжилт
1	2	3	4	5
Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тэдэнд хүндэтгэлтэй хандаж түргэн шуурхай үйлчлэх, дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд:				
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний саадгүй нэвтрэх дэд бүтэц бүхий барилга байгууламжийн судалгааг гаргах	Судалгааны сан	1	Соёмбо цогцолбор нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шат, шатны бариулыг байршуулсан байна.
2	Улсын бүртгэлийн зарим нэг үйлчилгээний талаарх мэдээллийг дохионы болон хадмал орчуулгатай хүргэх	Байгууллагын цахим сайтад шинээр оруулсан мэдээ, мэдээллийн тоо, түүнээс дохионы болон хадмал орчуулгатай хүргэсэн мэдээллийн тоо	4	Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэх зорилгоор хугацаатай бүртгэлүүдээр контент бэлтгэхээр иргэн Өлзийсайхантай холбогдон сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст дохионы хэлээр видео контент бэлтгэхээр контентийн санааг бэлтгэж байна.
3	Харааны бэрхшээлтэй иргэдэд тохирсон тухайн улсын бүртгэлийн мэдээллийг брайл үсгээр хэвлүүлэн үйлчилгээний хэсгүүдэд байршуулах	Гарын авлага танилцуулгын тоо	3	Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх гарын авлагыг сул хараатай, харааны бэрхшээлтэй хүн, хүүхдэд брайл үсгээр хийлгэхээр судалж байна. Үйлчилгээний зааланд үйлчлүүлэхээр ирсэн хараа муутай иргэдэд хол, ойрын харааны шилийг

				байршуулсан. Мэдээллийн самбарт болон гарын авлагыг үсгийн фонтын хэмжээг 14 болгон хэвлэж Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулж гарын авлагыг байршуулсан.
4	Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулж дуудлага.мн –тэй холбогдож дүрст дуудлага хийх боломжийг олгох	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	1	Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэх зорилгоор хугацаатай бүртгэлүүдээр контент бэлтгэхээр иргэн Өлзийсайхантай холбогдон сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст дохионы хэлээр видео контент бэлтгэхээр контентийн санааг бэлтгэж байна. Мөн үйлчилгээний зааланд сууж буй улсын бүртгэгч нар дохионы хэлний багшгүйгээр өөрийн утсаар хөгжлийн бэрхшээлтэй тэр дундаа хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд дохионы хэлний видео дуудлагыг www.duudlaga.mn зайнаас зөвлөн туслах үйчилгээтэй шууд холбогдох боломжтой болсон.
5	Үйлчилгээний зааланд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээ бүхий цонх бий болгож, дугаар харгалзахгүй үйлчлэх нөхцөл бололцоогоор хангах	Цонх тэмдэг тэмдэглэгээ	1	Тус хэлтсийн үйлчилгээний зааланд сууж буй улсын бүртгэгч нарын цонхонд ахмад настан, жирэмсэн эх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх тэмдэг тэмдэглэгээг нааж дугаар харгалзахгүй үйлчлэх бололцоогоор бүрэн хангасан.
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 4G зөөврийн тоног төхөөрөмжөөр явуулын үйлчилгээ үзүүлэх	Батлагдсан удирдамжийн тоо	-	Сайншанд сумын 1 дүгээр багийн 1 иргэнд, 2 дугаар багийн 1 иргэн нийт 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 4G зөөврийн тоног төхөөрөмжөөр буюу явуулын үйлчилгээгээр иргэний үнэмлэхийн сунгалтын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн мэдээллийг тогтмол хөтлөх	Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	1	Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга , улсын ахлах бүртгэгч Б.Баттуяа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн тухай мэдээллийг

				тухай бүр хөтөлж хэвшсэн.
Хоёр. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:				
8	Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах талаар бодлого дэмжлэг үзүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч, ажилтны тоо	-	Тус хэлтэст хөгжлийн бэрхшээлтэй 2 албан хаагч ажиллаж байна.
9	Салбарын хэмжээнд байгаа хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын судалгаа, квотын хэрэгжилтийн мэдээллийг нэгтгэн холбогдор байгууллагад хүргүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ		Тус хэлтэст ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон гэр бүлийн гишүүдийн хүрээнд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэний судалгааг гарган 2024 оны 03 сарын 05-ны өдөр ochirbat@burtgel.gov.mn хаягаар хүргүүлсэн. оролцох эрхийг хангаж өгсөн.
10	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асардаг ажилтан хүсэлт гаргасан тохиолдолд ажил олгогч түүнд гэрээсээ, зайнаас, бүтэн бус цагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжит арга хэмжээг авах	Хэрэгжүүлсэн арга хэмжээ		Тус хэлтсийн гэрээт ажилтан Д.Баярсайханы хүү хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд хүүгээ насан туршийн боловсролын сургуульд хүргэж өгөх, авахад нь зориулж ажлын цагт нь зохицуулалтыг хийн хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш эрхийг хангаж өгсөн.
11	Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, ээлжит эмчилгээ, сувилгаанд хүсэлтийг нь харгалзан дэмжлэг, тусламж үзүүлэх	Хамрагдсан албан хаагчдын тоо	-	Хөгжлийн бэрхшээлтэй 2 алба хаагчид нь тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, эмчийн хяналтанд байдаг. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4 заасны дагуу ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдрөөр олгож амраадаг.
12	Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж болох ажил, албан тушаалын жагсаалтыг ил тод болгох	Мэдээлсэн тоо	-	Үйлчилгээний танхимд ажиллаж буй улсын бүртгэгчийн албан тушаал, нэр, ажлын байрны зорилт, чиг үүргийг тодорхой бичиж байршуулсан.
Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухайх уулийн 7 дугаар зүйл/ Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг,				

ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд				
13	Дохионы хэлний хэлмэрч бэлтгэх сургалтад албан хаагчдыг шинээр нэмж сургах	Албан хаагчид хамрагдсан байна.	-	Улсын бүртгэгч Э.Ариунтуяа, Б.Баттуяа нар УБЕГ-аас зохион байгуулж байсан дохионы хэлний сургалтанд тухай бүр хамрагдаж байсан. Сонсгол хэл ярианы бэрхшээлтэй хүнд байууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэх анхан шатны үгс болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй яаж харьцаж ойлголцох талаар анхан шатны чадвартай болсон.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

